

ХЭРЭГЛЭГЧДИЙН СУДЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ТАЛААР

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 11-р тогтоолын дагуу Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт иргэдийн ахуй амьдрал, амьжиргааны түвшинд хэрхэн нөлөөлж байгааг тодруулах зорилгоор иргэдийн дунд санал асуулгыг 2010 онд 4-удаагийн давтамжтай 13 суманд зохион явуулж 1400 иргэн судалгаанд хамрагдлаа. Энэ нь өнгөрсөн оноос судалгаанд оролцсон иргэдийн тоо 2 хувиар нэмэгдэж 5 хувьд хүрсэн билээ. Иргэдийг судалгаанд хамруулахдаа хөдөөгийн сум /12/ тус бүрээс 100, Баруун-Урт сумаас 200 иргэнийг хамруулахаар төлөвлөж уг ажлыг зохион явуулав.

Судалгааг явуулахдаа “Иргэний нийгмийн сүлжээ” төрийн бус байгууллага болон “Шинэ үеийн эхлэл” төрийн бус байгууллагуудыг бие даан оролцох нөхцөл боломжийг хангаж ажиллав. Энэ ажлын хүрээнд Засаг даргын нөөц сан болон Тамгын газрын төсвөөс 1.0 сая төгрөгийг гарган зарцуулсан байна. Харин 2011 онд хэрэглэгчдийн судалгааны зардалд 1.6 сая төгрөгийг төсөвлөн аймгийн төсвийн тодотголын хэлэлцүүлэгт оруулахаар саналаа хүргүүлээд байна.

Судалгаанд нийт 1400 хүн оролцсоны 260 нь төсөвт байгууллагаас, 290-нь хувийн хэвшил, бизнес эрхлэгчдээс, 270-нь малчин, 410-нь ажилгүй иргэд, 170-нь төрийн бус байгууллагаас хамрагдсан байна. Мөн үүнээс гадна агентлаг, албадын үйл ажиллагаатай холбогдуулан байгууллага тус бүрт 50 иргэн нийт 1200 иргэнийг хамруулсан судалгааг судалгаа шинжилгээний чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байгаа орон нутгийн “Шинэ үеийн эхлэл” төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр хийлгүүлсэн юм.

Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилттэй холбогдсон 8 асуулттай асуулгын дүнг нэтгэж үзэхэд **76.7** хувийн гүйцэтгэл, **3.83** оноотойгоор үнэлэгдсэн байна. Энэ байдал нь тус аймгийн хувьд тодорхой хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, иргэдэд дэмжлэг туслалцаа үзүүлэх зэргээр зарим бодлогын хэрэгжилт иргэдэд үр дүнтэй хүрч буйг илтгэн харуулж байгаа хэрэг билээ.

Орон нутагт зохион явуулсан судалгааны дүнгээс харахад төрийн байгууллагууд иргэдэд ил, тод, хөнгөх шуурхай үйлчлэх, иргэдийн өргөдөл гомдлыг цаг хугацаанд барагдуулах, сумдын төсөвт байгууллага, Засаг даргын эрхлэх хүрээний агентлаг албадын үйл ажиллагаа тогтмолжиж байгаа нийтлэг давуу талууд байгаа боловч ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, архидалт, үнийн өсөлтийг бууруулах талаар цаашид дорвитой арга хэмжээг бодлогын хүрээнд авч хэрэгжүүлэх шаардлагатай нь харагдаж байна. Мөн сум орон нутгийн түвшинд боловсон хүчний чадварыг дээшлүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, шинэ ажлын байрыг олноор нэмэгдүүлж ажиллах нь тулгамдсан гол асуудал болоод байгаа нь иргэдээс авсан бичгэн саналын дүнгээс харагдаж байгаа юм. Иймээс цаашид дээрхи асуудлуудыг шийдвэрлэхэд бодлогын төлөвлөлт болон үйл ажиллагааг чиглүүлж, төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Дашрамд хэлэхэд энэ оноос хэрэглэгчдийн судалгааг хийхдээ зөвхөн асуулгын аргыг ашиглах тус социологийн олон олон түгээмэл аргуудыг ашиглахаар шинжилгээ, судалгааны ажил хийгдэж байгаа болно.